



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,
Цахим шуудан: info@namem.gov.mn

2025.10.20 № 01/455
танай _____-ны № _____-т

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМАНД**

Тус газар болон харьяа байгууллагуудын
2025 оны гурав дугаар улирлын "Шилэн данс"-ны
хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний
үр дүнгийн танилцуулгыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 6 хуудастай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

153250773

Цаг уур, орчны шинжилгээний газрын
2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
01/75 дугаар албан бичгийн хавсралт

**ЦАГ, УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
2025 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР “ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг: Хяналт шинжилгээний зорилго

“Шилэн дансны тухай” хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг 2025 оны 3 дугаар улирлын мэдээнд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор ажиллав.

“Шилэн дансны тухай” хуулийг үндэслэн Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам” батлагдсанаар холбогдох мэдээллийг олон нийтэд мэдээлэн, төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн хэрэгжилтэд иргэдээс хяналт тавих нөхцөлийг бий болгож байгаа чухал ач холбогдолтой юм.

Хоёр: Ажлын бүрэлдэхүүн, хугацаа

“Шилэн дансны тухай” хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд Хяналт, шинжилгээ дотоод аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Баасансүрэн 2025 оны 3 дугаар улирлын мэдээлэлд хяналт хийж ажиллан дүгнэв.

Гурав: Хуулийн хэрэгжилтийн хамрах хүрээ

1. Төсвийн шууд захирагч нар 20 төрлийн мэдээллийг www.shilendans.gov.mn байршуулахаар заасан бөгөөд эдгээр мэдээллийг тайлагнах хугацаа, мэдээллийн агуулгаас хамааран 5 бүлэгт хуваадаг. Үүнд:

- Бүтэн жилээр оруулах мэдээлэл
- Хагас жилээр оруулах мэдээлэл
- Улирал бүр оруулах мэдээлэл
- Сар бүр оруулах мэдээлэл
- Тухай бүр оруулах мэдээлэл

2. Тухайн журмын 8-ийн 8.1-д заасны дагуу шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана, мөн 8.2-т дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргаан төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргэх үүрэгтэй.

3. “Шилэн дансны тухай” хуулийн дагуу Цаг, уур орчны шинжилгээний газар нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн 1, төсвийн шууд захирагчийн 25 нийт 26 байгууллагыг хамруулан тус хуулийн хэрэгжилтийг мэдээллийн ангилал тус бүрээр өөрийн цахим хуудас болон www.shilendans.gov.mn сайтад байршуулан иргэд, олон нийтэд мэдээлж байгаад хяналт шинжилгээ хийж зөвлөмж, дүгнэлтийг өгч ажилласан болно.

Дөрөв: Тайлант хугацаанд гүйцэтгэсэн ажлын нэгдсэн тайлангийн үр дүн

Мэдээ оруулсан байдал:

Цаг, уур орчны шинжилгээний газрын 2025 оны 3 дугаар улирлын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг байгууллага тус бүрээр www.shilendans.gov.mn сайтаас шүүн ажиллахад төсвийн төвлөрүүлэн захирагчийн/1/, төсвийн шууд захирагч/25/-дын цахим сайтад байршуулах 29 төрлийн 3692 мэдээллийг хугацааны ангиллаар харуулахад дараах байдалтай байна. Үүнд:

Нийт оруулсан нэгдсэн мэдээлэл;

№	Хугацааны ангилал	Байршуулсан мэдээллийн	
		Тоо	Хувь
1	Хугацаандаа оруулсан	3670	99,4
2	Хугацаа хоцорсон	22	0,6
	Мэдээлэл оруулаагүй	0	0
Нийт		3692	
Хуулийн хэрэгжилт		99,4%	

1. Бүх байгууллагын нийт мэдээний 99,4 хувь нь 2025 оны 3 дугаар улирлын тайланг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1 заасан хугацаанд буюу дараа сарын 15-аас өмнө байгууллагын нэгдсэн админд цахим хэлбэрээр илгээсэн болно.

2. Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудас болон Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллийг оруулж хэвшсэн бөгөөд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 3692 мэдээлэл оруулахаас 3670 мэдээллийг хугацаанд нь 22 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

3. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт 2025 оны 3 дугаар улирлын байдлаар байдлаар нийт 99,4 хувийн хэрэгжилттэй буюу өмнөх оны мөн үеэс 0,2%-иар чанар сайжирсан үзүүлэлттэй гэж дүгнэгдэв.

Тав: Дүгнэлт

5.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 1, төсвийн шууд захирагчийн 25 www.shilendans.gov.mn сайтад байршуулсан мэдээллийн агуулга, хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд хуульд заасан хугацааны дагуу мэдээллээ оруулж байгаа боловч “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хавсралтад заасан хүснэгтийн дагуу мэдээллээ PDF, XML форматаар цахимаар архивлаж, холбогдох тайлбарыг бүрэн оруулсан нь хуулийн хэрэгжилт өмнөх оны мөн үеэс 0,2 хувиар өссөн гэж дүгнэж байна.

5.2 “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт хугацаа хоцроож мэдээллээ оруулсан, улирлын тайланг дараа сарын 15-аас өмнө хоцроож, 97,9% буюу түүнээс доош дүгнэгдсэн 2 байгууллагыг дараах байдлаар харуулав. Үүнд:

5.2.1 Хуулийн хэрэгжилт хувь буурахад нөлөөлсөн байгууллагууд

- Баянхонгор аймгийн Ус, цаг, уур орчны шинжилгээний төв нь нийт 142 мэдээлэл оруулах ёстойгоос 136 мэдээлэл хугацаанд нь оруулж, 6 мэдээллийг хугацаа хоцруулан хэрэгжилт 95,8 хувийн гүйцэтгэлтэй.
- Ховд аймгийн Ус, цаг, уур орчны шинжилгээний төв нь нийт 142 мэдээлэл оруулах ёстойгоос 136 мэдээлэл хугацаанд нь оруулж, 4 мэдээллийг хугацаа хоцруулан хэрэгжилт 97,2 хувийн гүйцэтгэлтэй.

Нийтлэг гаргасан алдаа: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ гэсэн мэдээг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дэх хэсгийн 3.2.10 дахь заалтад заасны дагуу үнэн зөв мэдээг хавсралтын дагуу оруулаагүй байна. Үүнд: Зөвхөн тушаал шийдвэр, гэрээ оруулна. Үнэлгээний хорооны тэмдэглэл, зөвлөмж, ирсэн, явсан бичиг, гэрээний төсөл оруулахгүй. Гэрээний хугацаа дууссан эсэхийг анхаарах, мөн илүү оруулсан баримтуудыг хасах, Тухай ажлын хүрээнд хийсэн ажлын тайлан, тухайн хувь хүний мэдээлэл, иргэний үнэмлэхийг оруулахгүй байхыг анхаарах шаардлагатай.

Зургаа: Зөвлөмж

Төсвийн шууд захирагч болон нягтлан бодогч нарт дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

“Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хэвшүүлэх талаар үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд нь хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах, ажлын хариуцлагыг өндөржүүлэн ажиллах;

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дэх хэсгийн 3.2.10. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар; тогтоосон хугацаанд нь нийтэд мэдээлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Шилэн дансны тухай” хуулиар хүлээсэн үүргээ хугацаа хоцроож биелүүлсэн Улаанбаатар хотын, Баянхонгор, Сүхбаатар, Увс, Ховд, Хэнтий, Говьсүмбэр аймгуудын Ус, цаг, уур орчны шинжилгээний төв болон Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори, Нислэгийн цаг уур мэдээллээ хоцроохгүй байх тал дээр анхаарч, ажлаа сайжруулах шаардлагатай байна. 2025 оны 3-р улиралд Баянхонгор, Өмнөговь, Ховд, Хэнтий аймгуудын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвүүд тус бүр нэг, нэг мэдээ нэмж хугацаа хоцроож оруулсан байна. Давтан мэдээллээ удаа дараа хоцроосон албан хаагчдад хариуцлага тооцохыг анхаарах;

Зөвхөн тушаал шийдвэр гэрээ оруулна. Топнэт Гэрээний хугацаа 5-р сард дууссан байна. Үнэлгээний хорооны тэмдэглэл, зөвлөмж, ирсэн явсан бичиг оруулахгүй. Гэрээний хугацаа дууссан эсэхийг анхаарах Оргил цамхаг констракшн зөвхөн гэрээ, тушаал оруулах илүү баримтуудыг хасах, Ординат ХХК-с ирсэн бичиг, гэрээний төсөл оруулахгүй, Өөдрөг иргэн ажлын хүрээнд хийсэн ажлын тайлан хүний иргэний үнэмлэхийг оруулахгүй байх, ёст бэст сервэр зөвхөн тушаал, шийдвэр гэрээг оруулах

“Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд улирал бүр дотоод аудит хяналт шинжилгээ хийдэг гэдгийг шинээр тухайн байгууллагад орж, ажиллаж байгаа холбогдох албан хаагч, нягтлан бодогчдод хэлж, мэдээллээ хуулийн хугацаанд үнэн зөв бодитоор /долоо хоног, сар, улирал, хагас, бүтэн жил/ тогтмол оруулж хэвшихийг үүрэг болгох;

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1 заалтын дагуу журмын хэрэгжилтийн улирлын тайланг байгууллагын нэгдсэн админд тогтмол илгээж байх;

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын хавсралтад заасан хүснэгтийн дагуу мэдээллээ PDF, XML форматаар цахимаар архивлаж, холбогдох тайлбарыг бүрэн оруулж шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулж хэвшихийг зөвлөж байна.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРЫН 2025 ОНЫ III УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

№	Байгууллага	Төсөв/гүйцэтгэл				Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт				Бусад				дүн				хувь		
		Нийт	Хугацаа даа оруулсан	Хугацаа хоцорсон	мөдөртэй оруулсанг ү	Нийт	Хугацаа даа оруулсан	Хугацаа хоцорсон	мөдөртэй оруулсанг ү	Нийт	Хугацаа даа оруулсан	Хугацаа хоцорсон	мөдөртэй оруулсанг ү	нийт	Хугацаа даа оруулсан	Хугацаа хоцорсон	мөдөртэй оруулсанг ү	нийт	Хугацаа даа оруулсан	Хугацаа хоцорсон
1	Цаг, уур орчны шинжилгээний газар	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
2	Архангай УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
3	Баян-Өлгий УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
4	Баянхонгор УЦУОШГ	57	53	4	0	30	30	0	0	55	53	2	0	142	136	6	0	100.0	95.8	4.2
5	Булган УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
6	Говь-Алтай УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
7	Дорноговь УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
8	Дорнод УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
9	Дундговь УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
10	Завхан УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
11	Өвөрхангай УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
12	Өмнөговь УЦУОШГ	57	56	1	0	30	30	0	0	55	54	1	0	142	140	2	0	100.0	98.6	1.4
13	Сүхбаатар УЦУОШГ	57	56	1	0	30	29	1	0	55	55	0	0	142	140	2	0	100.0	98.6	1.4
14	Сэлэнгэ УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
15	Төв УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
16	Увс УЦУОШГ	57	56	1	0	30	30	0	0	55	55	0	0	142	141	1	0	100.0	99.3	0.7
17	Ховд УЦУОШГ	57	56	1	0	30	28	2	0	55	54	1	0	142	138	4	0	100.0	97.2	2.8
18	Хөвсгөл УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
19	Хэнтий УЦУОШГ	57	55	2	0	30	30	0	0	55	55	0	0	142	140	2	0	100.0	98.6	1.4
20	Дархан-Уул УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
21	Орхон УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
22	Говьсүмбэр УЦУОШГ	57	57	0	0	30	30	0	0	55	54	1	0	142	141	1	0	100.0	99.3	0.7
23	Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори	57	56	1	0	30	30	0	0	55	55	0	0	142	141	1	0	100.0	99.3	0.7
24	Улаанбаатар хотын УЦУОШГ	57	55	2	0	30	30	0	0	55	55	0	0	142	140	2	0	100.0	98.6	1.4
25	Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн	57	57	0	0	30	30	0	0	55	55	0	0	142	142	0	0	100.0	100.0	0.0
26	Нислэгийн цаг уурын төв	57	56	1	0	30	30	0	0	55	55	0	0	142	141	1	0	100.0	99.3	0.7
	нийт дүн	1482	1468	14	0	780	777	3	0	1430	1425	5	0	3692	3670	22	0	100.0	99.4	0.6
	хувиар	100.00	99.1	1.0	0.0	100.0	99.6	0.4	0.0	100.0	99.7	0.4	0.0	100.0	99.4	0.6	0.0	100.0	99.4	0.6

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРЫН 2025 ОНЫ III УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Харьяа байгууллага, санхүүгийн тайлангийн нэр		Цаг уур, орчны шинжилгээний газар	Архангай УЦУОШГ	Баян-Өлгий УЦУОШГ	Баянхонгор УЦУОШГ	Булган УЦУОШГ	Говь-Алтай УЦУОШГ	Дорноговь УЦУОШГ	Дорнод УЦУОШГ	Дундговь УЦУОШГ	Завхан УЦУОШГ	Өвөрхангай УЦУОШГ	Өмнөговь УЦУОШГ	Сүхбаатар УЦУОШГ	Сэлэнгэ УЦУОШГ	Төв УЦУОШГ	Увс УЦУОШГ	Ховд УЦУОШГ	Хөвсгөл УЦУОШГ	Хэнтий УЦУОШГ	Дархан-Уул УЦУОШГ	Орхон УЦУОШГ	Товьсүмбэр УЦУОШГ	Байгаль орчин хэмжигдэхүүн төв лаборатори Улаанбаатар хотын УЦУОШГ	Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн төв	Нислэгийн цаг уурын төв	дүн		
		142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	142	3692		
Шигшээ дэвсгэрийн тухай хуулийн мэдээлэл	Нийт байршуулсан мэдээлэл	142	142	142	136	142	142	142	142	142	142	142	140	140	142	142	141	138	142	140	142	142	141	141	140	142	141	3670	
	Мэдээллээ хугацаа хоцроож байршуулсан	0	0	0	6	0	0	0	0	0	0	0	2	2	0	0	1	4	0	2	0	0	1	1	2	0	1	22	
Төсөв, гүйцэтгэл	Мэдээллийг хугацаандаа байршуулаагүй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0		
	Сар бүр																												
	1 Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	234	
	2 Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	234	
	Хагас жил																												
	3 Санхүүгийн тайлан	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	52	
	4 Хандив, тусламжийн орлого	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	26	
	5 Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	26	
	6 Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	26	
	Жил бүр																												
	7 Санхүүгийн тайлан	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	26	
	8 Байгууллагын батлагдсан төсөв	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	26	
	9 Дараа жилийн төсвийн төсөл	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	26	
	10 Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	26	
	11 Хандив, тусламжийн орлого	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	26	
	12 Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	26	
	13 Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	26	
	Тухай бүр																												
	14 Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	234
	15 Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	234
16 Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	234	
дүн	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	57	1482	
Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	Сар бүр																												
	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9	234	

[illegible]